

**ГОВЬ ХК-ИЙН 2022 ОНЫ 1-Р УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/

<p><i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулалт хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i></p>
--

<i>Тайллагнах хугацаа</i>	2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Үнэт цаасны код, утасны дугаар</i>	<i>Компанийн нэр: "Говь" ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Утасны дугаар: (+976) 7013-9977</i>
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын Хөрөнгийн Бирж
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Ямааны ноолуур, тэмээний ноосонд боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо шиরхэг</i>	780,112,500
<i>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	<i>Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Ч.Солонго /Тэргүүн дэд захирал/</i>
1.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>
2.	<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>
3.	<i>Орлогын тайлан</i>
4.	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>
5.	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>

*1-р улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг хавсаргав.
/Хавсралт-1/*

2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлон удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт																			
	Эрсдэл, аудитын хорооны шийдвэрийг хамт хавсаргав. /Хавсралт-2/																			
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																			
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт (өссөн)</th> <th>2021.3 Гүйцэтгэл</th> <th>2022.3 Гүйцэтгэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Бохир ашгийн маржин</td><td>51%</td><td>47%</td></tr> <tr> <td>Цэвэр ашгийн маржин</td><td>-41%</td><td>-28%</td></tr> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td><td>0.7</td><td>0.8</td></tr> <tr> <td>Бараа материалын эргэц</td><td>969.9</td><td>663.9</td></tr> <tr> <td>Хувьцааны нэгж үнз /₹/</td><td>243.00</td><td>290.00</td></tr> </tbody> </table>	Үзүүлэлт (өссөн)	2021.3 Гүйцэтгэл	2022.3 Гүйцэтгэл	Бохир ашгийн маржин	51%	47%	Цэвэр ашгийн маржин	-41%	-28%	Эргэлтийн харьцаа	0.7	0.8	Бараа материалын эргэц	969.9	663.9	Хувьцааны нэгж үнз /₹/	243.00	290.00
Үзүүлэлт (өссөн)	2021.3 Гүйцэтгэл	2022.3 Гүйцэтгэл																		
Бохир ашгийн маржин	51%	47%																		
Цэвэр ашгийн маржин	-41%	-28%																		
Эргэлтийн харьцаа	0.7	0.8																		
Бараа материалын эргэц	969.9	663.9																		
Хувьцааны нэгж үнз /₹/	243.00	290.00																		
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																			
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	<ul style="list-style-type: none"> Өнгөрсөн оны эхний улиралд Ковид-19 цар тахлаас үүдэн улсын хил хаагдсан, мөн хэсэгчилсэн хөл хорио тавигдсантай холбоотойгоор дотоодын борлуулалт буурсан. Иймд хүмүүсийн бөөгнөрлийг багасгах, мөн борлуулалтаа нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны хоёрдугаар хагаст www.gobi.mn цахим хуудсыг ашиглалтад оруулж, худалдан авагчдад цахимаар худалдан авалт хийх боломжийг бүрдүүлсэн. 2022 онд компани нь дотоодод зарагдаж буй бэлэн бүтээгдэхүүний үнийг 15% өсгөсний үр дүнд 2022 оны I улирлын байдлаар дотоодын борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 54%, бохир ашгийн түвшин 8 пунктээр өссөн байна. Гадаад борлуулалтаа нэмэгдүүлэх, Говьбрэндийн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд таниулах зорилгын хүрээнд олон улсад онлайн худалдааны сувгуудаа эрчимтэй нэмэгдүүлэн, маркетинг идэвхжүүлэлтийн ажлууд дээр төвлөрч ажилласан. Европ тивийн нөхцөл байдалтай холбоотойгоор 2 веб сайтыг хаасан. 2022 оны эхний улиралд Хятад болон АНУ дахь охин компанийн борлуулалт өнгөрсөн оны мен үеэс харгалзан 99% болон 9%-иар тус тус өссөн бол EU охин компанийн борлуулалт 7% буурсан байна. 																		
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.																		

4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>																		
	<i>(мян.төг)</i>																		
	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="text-align: left; padding: 2px;">ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ</th><th style="text-align: right; padding: 2px;">2022.03.31</th></tr> </thead> <tbody> <tr> <td style="padding: 2px;">Холбоотой талд өгсөн санхүүжилт</td><td style="text-align: right; padding: 2px;">30,927,360</td></tr> <tr> <td style="padding: 2px;">Холбоотой талаас авсан санхүүжилт</td><td style="text-align: right; padding: 2px;">60,277,483</td></tr> <tr> <td style="padding: 2px;">Холбоотой талтай хийсэн борлуулалт</td><td style="text-align: right; padding: 2px;">27,746</td></tr> <tr> <td style="padding: 2px;">Холбоотой талаас авсан худалдан авалт</td><td style="text-align: right; padding: 2px;">297,183</td></tr> <tr> <td style="padding: 2px;">Хүүгийн орлого</td><td style="text-align: right; padding: 2px;">-</td></tr> <tr> <td style="padding: 2px;">Хүүгийн зардал</td><td style="text-align: right; padding: 2px;">1,062,539</td></tr> <tr> <td style="padding: 2px;">Түрээсийн орлого</td><td style="text-align: right; padding: 2px;">69,693</td></tr> <tr> <td style="padding: 2px;">Түрээсийн зардал</td><td style="text-align: right; padding: 2px;">209,911</td></tr> </tbody> </table>	ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ	2022.03.31	Холбоотой талд өгсөн санхүүжилт	30,927,360	Холбоотой талаас авсан санхүүжилт	60,277,483	Холбоотой талтай хийсэн борлуулалт	27,746	Холбоотой талаас авсан худалдан авалт	297,183	Хүүгийн орлого	-	Хүүгийн зардал	1,062,539	Түрээсийн орлого	69,693	Түрээсийн зардал	209,911
ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ	2022.03.31																		
Холбоотой талд өгсөн санхүүжилт	30,927,360																		
Холбоотой талаас авсан санхүүжилт	60,277,483																		
Холбоотой талтай хийсэн борлуулалт	27,746																		
Холбоотой талаас авсан худалдан авалт	297,183																		
Хүүгийн орлого	-																		
Хүүгийн зардал	1,062,539																		
Түрээсийн орлого	69,693																		
Түрээсийн зардал	209,911																		
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжисэж эхэлснээс хойших төслийн хэрэгжсилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i>																		
	<i>Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.</i>																		
6.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>																		
	<p>“Говь” ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн 1-р ангилал, ТОП 20 индекст багтдаг нээлттэй хувьцаат компани бөгөөд эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Манай компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм. Бид үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, СЗХ, МХБ-ийн холбогдох дүрэм, журмыг баримтлан ажилладаг.</p> <p>2022.03.31-ний байдлаар нийт 22,151 хувьцаа эзэмшигчидтэй байна. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь Таван Богд Трейд ХХК (392,028,206 ширхэг хувьцаатай буюу 50.25% эзэмшдэг) болон Хиде Интер ХХК (265,238,300 ширхэг хувьцаатай буюу 34.00% эзэмшдэг) юм.</p> <p>2020.04.24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТҮЗ-ийн 9 гишүүд (5 хараат бус, 4 ердийн гишүүн)-ийг 3 жилийн хугацаатайгаар томилсон бөгөөд ТҮЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.</p> <p>ТҮЗ-ийн дэргэд 3 хороо (Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо) үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТҮЗ-ийн ээлжит хурал хоёр сар тутам, Эрсдэл аудитын хороо улирал тутам, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороо жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТҮЗ-ийн гишүүд өөрийн эрх үүргийн хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.</p> <p>ТҮЗ-ийн зүгээс жил бүр компанийн засаглалын үнэлгээг хийж МХБ болон өөрийн веб хуудсаар дамжуулан тайлагнадаг бөгөөд ТҮЗ-ийн өөрийн үнэлгээг дотооддоо тогтмол хийн үйл ажиллагаагаа дүгнэн сайжруулдаг.</p> <p>“Говь” ХК нь сайн засаглалын туршлагуудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт асуулт бүрд дор бүр нь хариу өгч ажилладаг.</p>																		

7.	<i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл.</i>
	<p>2022.01.01-2022.03.31-ний байдлаар Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурлыг 2022.01.17-ны өдөр, Цалин урамшууллын хорооны ээлжит хурлыг 2022.01.19-ний өдөр, ТУЗ-ийн ээлжит хурлыг 2022.01.25-ны өдөр, 2022.02.14-ний өдөр, Эрсдэл аудитын хорооны ээлжит хурлыг 2022.03.31-ний өдөр тус тус зохион байгуулан ажилласан. Тус хугацаанд нийт 7 тогтоолыг (үйл ажиллагаатай холбоотой 6 тогтоол, санхүүжилттэй холбоотой 1 тогтоол) баталж, 2 ээлжит бус хурлыг зарлан хуралдуулсан.</p> <p>Говь ХК нь Засаглалын өөрийн үнэлгээг 5 дахь жилдээ хийсэн бөгөөд 2021 оны компанийн засаглалын өөрийн үнэлгээний нэгдсэн дун 92.2% буюу өмнөх оноос 3%-ийн өссөн үзүүлэлттэй гарсан. Тус үнэлгээг 2022 оны 1 сарын 17-ны өдрийн Нэр дэвшүүлэх хорооны хурал, 2022 оны 1 сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар тус тус хэлэлцэн, өөрийн веб хуудас /info.gobi.mn/ болон МХБ-ийн веб хуудсаар дамжуулан олон нийтэд тайлagnасан.</p> <p>Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд info.gobi.mn компанийн веб хуудаст тогтмол мэдээлэл оруулан хувьцаа эзэмшигчдээ мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланг төлөвлөгөөт хугацаанд буюу 2022 оны 3 сарын 31-ний өдөр зохицуулагч байгууллагууд руу илгээн МХБ-ийн веб хуудас, компанийн өөрийн веб хуудаст нийтлэн олон нийтэд тайлagnан ажилласан.</p> <p>2022.03.31-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 1, 2 дугаар ангилалд бүртгэлтэй 60 хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт сургалт зохион байгуулж, Говь ХК-ийн ТУЗ-ийн мэргэжилтэн хамрагдсан. Тус сургалтаар шинэчлэгдсэн компанийн засаглалын кодекс, мэдээллийн нээлттэй ил тод байдал болон бусад засаглалтай холбоотой сайжруулах зөвлөмж мэдээллийг авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>2022.04.08-ний өдөр Хaalттай өрийн хэрэгслийн 1-р улирлын мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо-нд илгээн хуулийн хугацаанд тайлagnан ажилласан.</p>

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

<p>Овог, нэр: Ц.Баатарсайхан</p> <p>Албан тушаал: “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: </p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>Овог, нэр:</p> <p>Албан тушаал : “...” Аудитын компанийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
--	--

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: 

Говь ХК-ийн 2022 оны 1-р улирлын тайлангийн
Хавсралт-1



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОН
ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 оны 03 сарын 31

(мян.төгрөг)

2022.03.31 2021.12.31

ХӨРӨНГӨ**Эргэлтийн хөрөнгө**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,539,906	4,389,479
Дансны ба бусад авлага	2,206,483	2,258,129
Урьдчилгаа төлбөр	3,409,297	3,127,757
Бараа материал	137,401,907	138,030,372
	146,557,593	147,805,737

Эргэлтийн бус хөрөнгө

Үндсэн хөрөнгө	142,951,348	145,404,533
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	1,123,079	1,328,307
Хойшлогдсон татварын хөрөнгө	4,530,885	4,325,581
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	956,025	994,309
	149,561,337	152,052,730
	296,118,930	299,858,467

Нийт хөрөнгийн дүн**ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ****Богино хугацаат өр төлбөр**

Дансны ба бусад өглөг	39,851,551	15,982,955
Гэрээний өр төлбөр	2,734,864	1,370,281
Орлогын албан татварын өглөг	132,689	111,894
Богино хугацаат түрээсийн өглөг	920,203	914,850
Богино хугацаат банкны зээл	144,685,273	132,650,889
	188,324,579	151,030,870

Үрт хугацаат өр төлбөр

Үрт хугацаат түрээсийн өглөг	447,250	672,587
Үрт хугацаат банкны зээл	60,174,500	93,407,780
Үрт хугацаат өглөг	26,483,732	25,622,107
	87,105,483	119,702,474

Нийт өр төлбөрийн дүн**Эзэмшигчдийн өмч**

Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	48,870,401	48,870,401
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(712,193)	561,878
Хуримтлагдсан ашиг	(28,249,452)	(21,087,268)
	20,688,868	29,125,123
	296,118,930	299,858,467

Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн

(мян.төгрөг)

	2022.03.31	2021.12.31
Борлуулалтын орлого	25,633,949	144,344,329
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(13,516,139)	(85,543,487)
Нийт ашиг	12,117,810	58,800,842
Санхүүгийн ба бусад орлого	142,161	963,425
Бусад олз ба (гарз)	(986,217)	2,913,718
Санхүүгийн зардал	(4,939,119)	(25,474,286)
Борлуулалт ба маркетингийн зардал	(10,668,929)	(60,568,067)
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,021,181)	(14,636,714)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	-	(110,920)
Татварын өмнөх ашиг	(7,355,475)	(38,112,002)
Орлогын татварын өгөөж (зардал)	193,291	165,974
Тайлант жилийн цэвэр алдагдал	(7,162,184)	(37,946,028)
Дараа үеүдэд ашиг, алдагдал руу ангилагдах бусад иж бүрэн орлого:		
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(1,274,071)	1,923,910
Бусад дэлгэрэнгүй алдагдал	(1,274,071)	1,923,910
Нийт дэлгэрэнгүй алдагдал	(8,436,255)	(36,022,118)

(мян.төгрөг)

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	48,974,836	(1,362,032)	16,858,760	65,251,677
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(37,946,028)	(37,946,028)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	(104,435)	1,923,910	-	1,819,475
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал		(104,435)	1,923,910	(37,946,028)	(36,126,554)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	48,870,401	561,878	(21,087,268)	29,125,123
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(7,162,184)	(7,162,184)
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	(1,274,071)	-	(1,274,071)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	(1,274,071)	(7,162,184)	(8,436,255)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2022 оны 03 сарын 31-ний үлдэгдэл	780,113	48,870,401	(712,193)	(28,249,452)	20,688,868

(мян.төгрөг)

	2022.03.31	2021.12.31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(984,859)	19,987,525
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(47,919)	(212,013)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	208,740	(30,108,651)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(824,038)	(10,333,139)
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	(25,535)	1,923,873
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,389,479	12,798,745
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,539,906	4,389,479



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот


Г

2022 оны 1-р улирлын санхүүгийн
тайланг дүгнэх тухай

Т

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Говь” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ** нь:

- “Говь” ХК-ийн 2022 оны 1-р улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь үнэн зөв тайлагнагдсан болохыг баталсугай.
- Улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.



Б.НАНДИН-ЭРДЭНЭ
Д.ХУЛАН
А.ЖАРГАЛМАА